

## Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам, эцэг, эх, асран хамгаалагчаас төлөх төлбөрийн дээд хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Г.Батдорж/-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Чинзориг/-т тус тус даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын “Журам батлах тухай” 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/152 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

А.АРИУНЗАЯА

## **ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР, БОЛЗОЛ, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмаар хүүхэд харах үйлчилгээ эрхлэх шалгуур, бүрдүүлэх баримт бичиг, эцэг, эх, асран хамгаалагчаас төлөх төлбөрийн дээд хэмжээ, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, байгууллагын цэцэрлэгт хамаарахгүй.

### **Хоёр. Хүүхэд харах үйлчилгээний шалгуур**

2.1.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх орон сууц, байшин барилга, өрөө танхим, гэрийн гадаад, дотоод орчин нь “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6540:2015 Монгол Улсын стандартад нийцсэн байна.

2.2.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх иргэн /цаашид “хүүхэд харагч” гэх/ нь 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан нийтлэг шаардлагыг ханган, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 т заасны дагуу сум, дүүргийн Засаг даргаас үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан байна.

2.3.Хүүхэд харагч нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах, хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, зөв хооллох, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах арга зүйн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

### **Гурав. Бүрдүүлэх баримт бичиг**

3.1.Хүүхэд харагч нь хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

3.1.1. хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл;

3.1.2. иргэний үнэмлэх, үүсгэн байгуулагчийн өөрийн өмчлөлийн байрны лавлагаа, оршин суугаа хаягийн бүртгэлийн лавлагаа, /төрийн цахим үйлчилгээний мэдээллийн сангаас татаж хэвлэсэн байх/;

3.1.3.хэрвээ түрээсийн байр, гэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол түрээслэгчтэй байгуулсан гэрээ;

3.1.4.боловсролын диплом, бүрэн дунд боловсролын үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.1.5.журмын 2.3 дахь хэсэгт заасан сургалтад хамрагдаж авсан гэрчилгээний хуулбар;

3.1.6.иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/;

3.1.7.халдварт болон сэтгэцийн өвчингүй болохыг тодорхойлсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт;

3.1.8. хүүхэд харах үйлчилгээ эрхлэх объектын гадаад, дотоод орчин нь “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6540:2015 Монгол Улсын стандартыг хангасан талаарх баг, хорооны Засаг даргын дүгнэлт;

3.2.Баг, хорооны Засаг дарга журмын 3.1.8-д заасан санал, дүгнэлт гаргахдаа ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэл болгоно.

3.3.Энэ журмын 3.2-т заасан ажлын хэсэгт аймаг, /дүүрэг/-ийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын мэргэжилтэн, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, баг, хорооны нийгмийн ажилтан, эцэг, эх, иргэдийн төлөөллийг оролцуулна.

### **Дөрөв. Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох**

4.1.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэхийг хүссэн иргэн тухайн жилийн 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор энэхүү журмын 3.1-т заасан баримт бичгийг цахимаар эсхүл цаасан хэлбэрээр бүрдүүлж, сум, дүүргийн Засаг даргад саналаа хүргүүлнэ.

4.2.Сум, дүүргийн Засаг дарга баримт бичгийг хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.3.Шинээр зөвшөөрөл авсан хүүхэд харагч, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн талаарх мэдээллийг “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам”-д заасны дагуу цахимаар эсхүл цаасан хэлбэрээр бүрдүүлж, аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

4.4.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага шинээр зөвшөөрөл авсан болон үйл ажиллагаа явуулж байгаа хүүхэд харагч, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн талаарх мэдээллийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ.

4.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.4-т заасан мэдээллийг хянаж тухайн жилд хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тооны хязгаарт багтаан дараа оны төсвийг батлуулна.

4.6.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа хоёр жил байна.

4.6.1.Зөвшөөрлийн хугацааг сум, дүүргийн Засаг дарга нь баг, хорооны Засаг дарга болон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн нэг жилээр сунгана.

4.7.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой санал, гомдлыг харьяалах аймаг, нийслэл, дүүргийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч шалган шийдвэрлэж, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг зөрчсөн нь тогтоогдвол

энэ хуулийн 13.4-т заасны дагуу зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга хүчингүй болгоно.

### **Тав. Хүүхэд харагч бэлтгэх, чадавхжуулах сургалт зохион байгуулах**

5.1.Хүүхэд харагчийг бэлтгэх жишиг хөтөлбөрийн дагуу аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллага, хүүхэд хамгааллын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай хамтран хүүхэд харагчийг бэлтгэх сургалтыг зохион байгуулна.

5.1.1. Хүүхэд харагчийг бэлтгэх анхан шатны сургалт 3 кредит цаг;

5.1.2. Хүүхэд харагчийг чадавхжуулах давтан сургалт 2 кредит цаг;

5.2. Хүүхэд харагчийг бэлтгэх, давтан сургах, зөвлөмж мэдээллээр хангах, олон нийтэд тайлагнах ажлыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулах;

5.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах арга зүйн зааврыг баталж, мөрдүүлнэ.

### **Зургаа. Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах**

6.1.Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулахдаа Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, энэ журмыг мөрдөн ажиллана.

6.2.Хүүхэд харагч нь хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл, аюулгүй байдал, асаргаа, хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон гэрээ байгуулж ажиллана.

6.2.1.хүүхэд харах үйлчилгээний ажиллах цагийн хуваарь нь хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийн ажлын цаг, үйлчлүүлэх хэрэгцээнд нийцсэн байна.

6.2.2.хүүхэд харах үйлчилгээний ажлын цаг нь өдөрт найман цаг байх боловч эцэг эх, асран хамгаалагчтай харилцан тохиролцсон тохиолдолд хуульд нийцүүлэн илүү цагаар ажиллаж болно.

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг аймаг, нийслэлийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтийг үндэслэн үйлчилгээнд хамруулна.

6.4.Хүүхэд харах үйлчилгээний зөвшөөрөл авсан иргэн нь энэ журмын 5.1.1-д заасан сургалтад болон эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан иргэнийг сайн дурын үндсэн дээр дэмжин туслагчаар авч цалинжуулан ажиллуулж болно.

6.5.Хүүхэд харагч нь тус журмын 6.5-д заасан иргэнийг ажиллуулах тохиолдолд аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын нөөцөд байгаа хүүхэд харагч бэлтгэх сургалтад хамрагдсан иргэдээс сонгож ажиллуулна.

6.6.Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн ирцийн бүртгэлийг цахимжуулж, QR код уншуулна.

6.6.1.эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдээ орой хүлээн авах бүртээ гарын үсэг зурж баталгаажуулна.

6.7.Хүүхэд харагч нь хүүхэд харах явуулын үйлчилгээ эрхлэх тохиолдолд үйлчилгээний гадаад, дотоод орчин нь Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага ” MNS 6540:2015 Монгол Улсын стандартыг хангасан байх бөгөөд тухайн орон нутгийн захиргаанд заавал мэдэгдэнэ.

6.8.Хүүхэд харагч нь зөвшөөрөл авснаас хойш хүүхэд харах байраа өөрчилсөн тохиолдолд зөвшөөрөл олгосон байгууллагад 14 хоногийн дотор мэдэгдэж, хаягийн өөрчлөлт хийлгэнэ.

### **Долоо. Хүүхэд харах үйлчилгээнд эцэг, эх, асран хамгаалагчаас төлөх төлбөрийн дээд хэмжээ**

7.1.Эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хүүхэд харах үйлчилгээний орчныг сайжруулах, илүү цагаар ажиллах, хүүхэд хөгжүүлэх сургалтын тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт төлбөр төлж болох бөгөөд гэрээнд заавал тусгасан байна.

7.2.Эцэг, эх, асран хамгаалагчийн сард төлөх нэмэлт төлбөрийн дээд хэмжээ нь улсын төсвөөс олгож буй хоолны болон норматив зардлын нийлбэрийн 60 хувиас хэтрэхгүй байх бөгөөд эцэг, эхтэй хийх гэрээнд тусгасан байна.

### **Найм.Хүүхэд харагч, эцэг эх, асран хамгаалагч, төрийн захиргааны байгууллагын үүрэг**

8.1.Аймаг, /дүүрэг/-ийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага доор дурдсан үүрэг хүлээнэ:

8.1.1.энэхүү журмын 5.1-д зааснаас гадна хүүхэд харагч нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

8.1.2.хүүхэд харах үйлчилгээний мэдээллийг энэхүү журамд заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэх;

8.1.3.хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

8.1.4.хүүхдийн эрх, ашиг хохирох, хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой аливаа зөрчил, гомдлыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлүүлэх;

8.1.5.хүүхэд харах үйлчилгээнд тавих хяналтыг цахимаар болон биечилсэн хэлбэрээр зохион байгуулах;

8.1.6.хүүхэд харах үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахимжуулах;

8.1.7.төрийн байгууллагын ёс зүй, хэм хэмжээг баримтлан хүнд сурталгүй, ажиллах;

8.2. Хүүхэд харагч хуульд зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

8.2.1. хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөж, хэрэгжүүлэх;

8.2.2.хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд холбогдох төрийн байгууллага, Хүүхдийн тусламжийн 108 утас, эцэг, эх, асран хамгаалагчид заавал мэдээлэх;

8.2.3.хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх;

8.2.4.хүүхдийг сэтгэл зүйн болон бие махбодын хүчирхийлэл, үл хайхрах явдал, түлэгдэх, бэртэж гэмтэх зэрэг бүхий л эрсдэлд өртүүлэхгүй байх;

8.2.5.хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх;

8.2.6.хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн хөтөлбөрийг зохион байгуулах.

8.2.7. мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэх;

8.2.8.хүүхэд харах үйлчилгээний байранд гэрээнд зааснаас бусад, /хяналт шалгалтын ажилтан/ гадны хүн нэвтрүүлэхгүй байх;

8.2.9 төрийн цахим үйлчилгээнд холбогдсон байх;

8.3. Эцэг, эх, асран хамгаалагч доор дурдсан үүрэг хүлээнэ:

8.3.1.хүүхдээ эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах;

8.3.2.хүүхэд харагчтай хүүхдийн эрүүл, аюулгүй байдал, хөгжлийн чиглэлээр хамтарч ажиллах;

8.3.3.хүүхдийн биед тохирсон хувцас, сургалтын болон ариун цэврийн хэрэглэгдэхүүнээр хангах;

8.3.4. хүүхдээ аюулгүй тээвэрлэх;

8.3.5. хүүхэд харах үйлчилгээнд байнга хяналт тавих;

8.3.6.хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан үүргээ биелүүлж, хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхэд эрсдэлд өртсөн тохиолдолд холбогдох төрийн байгууллага, Хүүхдийн тусламжийн 108 утас, цагдаагийн 102 утсанд шуурхай мэдээлэх;

### **Ес.Хүүхэд харах үйлчилгээнд тавих хяналт**

9.1.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 15.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, баг, хороо, сум, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийн хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандарт, хүүхэд хамгааллын бодлого, зааврын хэрэгжилтэд хамтран хяналт тавьж ажиллана.

9.2.Сум, хорооны нийгмийн ажилтан, Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрхийн хууль тогтоомж, энэхүү журмын хэрэгжилтэд явцын хяналт тавина.

9.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага төлөвлөгөөт хяналт, шалгалт хийнэ.

9.4.Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс дараах чиглэлээр хяналт тавина:

9.4.1.хүүхдийн аюулгүй байдал, хоол, хүнс, асаргаа, хөгжүүлэх үйлчилгээний чанар, орчны аюулгүй байдалд;

9.4.2.хүүхэд харах үйлчилгээнд зориулан олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтад;

9.4.3.хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, хяналтын камерийн ашиглалт, хэвийн ажиллагаанд;

9.4.4.цахим бүртгэл болон хүүхдийн ирцийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлтөд;

9.4.5.хүүхэд харагчийн хүүхэдтэй ажиллаж буй арга барил, харилцаа, зан байдалд.

9.5.Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах нь хяналт шалгалтын ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-д санхүүжилт, стандартад нийсэн байдал зэргийг шалгах, танилцах боломжоор хангасан байна.

----oOo----

ТӨСӨЛ